

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТОЙМ

ОНЦЛОХ НЬ

- Усны аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үндэсний болоод бүс нутгийн хэмжээнд тогтвортой ажиллах институцийн тогтолцоо шаардагдана. Орон нутгийн түвшинд сав газрын байгууллага нь (СГБ) усны нөөцийн нэгдсэн менежментийг (УННМ) хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээж буй юм.
- СГБ нь сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, усны нөөцийг хамгаалах, амьдрах орчныг хамгаалах, усны зохистой хэрэглээг хангах үйл ажиллагаа явуулдаг. Гэвч бие даасан байдал хязгаарлагдмал, санхүүжилт хангалтгүй, мэргэжлийн чадавх дутагдалтай байгаа нь СГБ-ын хувьд тулгамдсан асуудал болж байна.
- Сав газрын захиргаа (СГЗ) нь тухайн голын сав газарт хамаарах аймгийн удирдлагуудтай хамтран ажиллах шаардлага их гардаг бөгөөд салбарын яамдууд, орон нутгийн засаг захиргаа, СГЗ-дын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь томоохон бэрхшээл болж байна.
- Төвлөрсөн бус УННМ-ийг хөгжүүлэх дараагийн алхам бол СГЗ-дыг УННМ-ийг тогтвортой хэрэгжүүлэх хөтөч болоход түлхэц өгөх явдал юм.

Монгол Улсад усны нөөцийн тогтвортой, нэгдсэн менежментийг нэвтрүүлэх нь: Сав газрын байгууллагын үүрэг, оролцоо

Мингюань Фан¹

Усны нөөцийн тэргүүлэх мэргэжилтэн

Зүүн Азийн бүсийн газар

Азийн Хөгжлийн Банк

mfan@adb.org

МОНГОЛ УЛСЫН УСНЫ НӨӨЦИЙН СИСТЕМ

Монгол улс нь газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 19-д ордог, мөн далайд гарцгүй хоёр дахь том орон юм.² 2018³ оны байдлаар нийт 1,56 сая хавтгай дөрвөлжин км газар нутагт тархан суурьшсан 3,2 сая хүн амтай бөгөөд нэг хавтгай дөрвөлжин км газарт 2 хүн ноогддог, дэлхий дээр хүн амын нягтаршил хамгийн багатай тусгаар тогтносон улс юм. Монгол улс нь 21 аймагт (засаг захиргааны нэгж) хуваагддаг бөгөөд аймаг бүр нь суманд хуваагдана.

Монгол улс 1990 он хүртэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны 5 жилийн төлөвлөгөөнд үндэслэн усны салбарыг хөгжүүлж байв. 1990-ээд оны эхэн үеийн ардчилсан хувьсгалын үр дүнд, усны менежментийн асуудлыг зах зээлд даатгаснаар төвлөрсөн удирдлага нь орхигдсон юм. Гэвч энэ хандлага бүтэлгүйтсэн бөгөөд усны байгууламжийн ихэнх систем эвдэрч, муудсан билээ. Засгийн газар энэ нөхцөл байдлыг ойлгоход нилээд удаан хугацааг

- ¹ Энэхүү тойм нь Азийн Хөгжлийн Банкаас (АХБ) Монгол улсын усны салбарын талаар хийсэн хоёр үнэлгээний тайлангийн үр дүн болон зөвлөмж дээр үндэслэсэн болно. АХБ. 2017. Монгол улсын усны аюулгүй байдлын үнэлгээ. Зөвлөхийн тайлан. Манила (ТТ8855-МОН); мөн М. Фан болон И.ван Бийк. 2020. Монгол Улсын усны нөөцийн систем, менежментийн тойм: Монгол улсын усны аюулгүй байдлын үнэлгээ. Манила. АХБ.
- ² Монгол улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Элчин сайдын яам, Женев дэх НҮБ-ын газар болон олон улсын байгууллагууд дахь Монгол Улсын төлөөлөгчийн газар. Газар зүй ба цаг уур.
- ³ Монгол Улсын Засгийн газар, Үндэсний статистик хороо. Монголын статистик мэдээллийн алба (2019 оны 4-р сарын 4-ний өдөр хандсан)

зарцуулсан бөгөөд усны менежментийг засгийн газрын үндсэн чиглэлийн нэг болгон сэргээсэн юм.⁴

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүтэц орон нутгийн сул хөгжилтэй эдийн засгаас хотжилт, үйлдвэржилт, уул уурхайн салбарын хурдацтай хөгжлөөр тодорхойлогдох хөгжиж буй холимог эдийн засаг руу шилжиж байгаа энэ үед усны салбарын хөгжил явагдаж байна. 2004 оноос хойш Монгол улсын Засгийн газар усны нөөцийн менежментийн институцийн тогтолцоог сэргээх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг аван ажиллаж байна. 2005 онд Усны хэрэг эрхлэх газар байгуулагдаж, сав газрын менежментийн анхны ойлголт, зарчмуудыг Усны тухай хуулиар тодорхойлж, ус ашигласны төлбөрийг мөн нэвтрүүлсэн юм. 2010 онд УИХ-аар "Ус үндэсний хөтөлбөр"-ийг (2010 оны УИХ-ын 24 дүгээр тогтоол) шинээр баталж, хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд: Эрчимтэй хөгжлийн 1-р үе шат (2010–2015) болон тогтвортой хөгжлийн 2-р үе шат (2016–2021). Усны үндэсний хөтөлбөрийн стратегийн зорилтод усны нөөцийн менежментийг бэхжүүлэх, усны нөөцийн зохистой хэрэглээг бий болгох, мөн сургалт сурталчилгаа явуулах, усны нөөц болон усны байгууллагуудын менежментийн эрх зүйн орчинг сайжруулах зэрэг асуудал оржээ. 2012 онд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар усны хэрэглээ болон хайгуулын ажлыг сайжруулах зохицуулалт хийгдсэн. Шинэчилсэн найруулгад усны нөөцийн ангилал, усны зохистой менежментийн ажлууд, ус ашиглах зөвшөөрөл олгох журмыг тодорхой зааж өгсөн. Монгол улсын усны нөөцийн менежментийн институцийн үндсэн тогтолцоо болсон усны сав газрыг тодорхойлох, сав газрын менежментийн төлөвлөгөө боловруулах, Сав газрын захиргаа (СГЗ) болон Сав газрын зөвлөл (СГЗө) байгуулахад удирдлага зохион байгуулалтын чиглэл өгөх дагалдах хууль тогтоомжийг баталсан. Хуучнаар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам буюу одоогийн Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь усны нөөцийн менежментийг хариуцах төрийн захиргааны төв байгууллага болохыг хуульд заасан болно.

Монгол улс усны аюулгүй байдлыг хангахын тулд усны систем болон байгаль орчны тэнцвэрийг хадгалах, мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээг хангах зэрэг нэлээдгүй бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал, Улаанбаатар хотын төв хэсэг, говь цөлийн бүсэд буй уул уурхайн үйл ажиллагааг усаар хангах, түүнчлэн зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай бусад бүс нутгууд орно. Нийслэл Улаанбаатар хот нь улсынхаа хамгийн том хот бөгөөд энд нийт хүн амын 47% орчим нь амьдардаг нь Монгол Улсыг харьцангуй өндөр хотжилттой орон (74%) болгож байгаа юм. Улаанбаатар хотын усан хангамж нь Туул голын ай савын газрын доорх усны эх үүсвэрээс ихээхэн хамааралтай (Газрын зураг 1). Энэхүү харьцангуй жижиг сав газар нь дангаараа тус улсын нийт хүн амын 50

орчим хувийг тэтгэдэг. Иймд усны нөөцийн урт хугацааны тогтвортой, аюулгүй байдлын хангахын тулд Монгол улсад нэгдсэн институцийн тогтолцоо шаардлагатай байгаа юм. Эдгээр институтууд нь усны нөөцийн нэгдсэн менежментийг (УННМ) хэрэгжүүлэх хэрэгтэй ба үүнд усны нөөцийн төлөвлөгөө боловсруулах, журмын хэрэгжилтийг хангах, төрийн удирдлага дор усны хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг бусад ажлуудыг хийх шаардлагатай байна.

САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ БАЙГУУЛАХ


Усны аюулгүй байдлыг сайжруулахад үндэсний болон бүс нутгийн түвшинд усны асуудал хариуцсан чадварлаг байгууллагууд байх шаардлагатай. Гол мөрөн нь засаг захиргааны хил дамнан урсдаг тул орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа маш чухал юм. Усны менежментийг сав газрын хэмжээнд явуулах нь тохиромжтой. Тиймээс хүчтэй, нэгдсэн зохион байгуулалттай тогтолцооны системийн чухал элемент бол олон улсын сайн туршлагад үндэслэн бүх 29 сав газарт (Газрын зураг 2) Сав газрын байгууллага (СГБ) байгуулах явдал юм. СГБ-ууд нь хоорондоо уялдаа холбоотой ажиллах бөгөөд бүс нутгийн түвшинд үр дүнтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх гол үүрэг хариуцлагыг хүлээдэг ба ингэснээр усны менежментийн төвлөрлийг сааруулж, усны менежментэд нийгмийн оролцоог идэвхжүүлдэг.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар 2010 онд Монгол улс 29 сав газарт хуваагдсан ба СГБ нь харьцангуй шинээр байгуулагдсан юм. Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй 21 СГЗ байгаа ба хамгийн анх Туул голын сав газрын захиргаа 2012 онд байгуулагдсан. СГБ тус бүр засгийн газрын, оролцогч талуудын, ус ашиглагчдын төлөөлөл (СГЗө-г бүрдүүлдэг) болон 5–12 усны мэргэжилтнүүдийн (СГЗ-г бүрдүүлдэг) бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулна. Эдгээр шинээр байгуулагдсан СГБ-уудын үйл ажиллагаа бүрэн жигдрэхэд нилээд цаг хугацаа шаардагдана.

СГБ-ууд нь УННМ-д суурилсан усны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн хоёр зорилтыг анхаарч ажиллана. Үүнд: Сав газар тус бүрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, мөн эдгээр төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих. СГБ-ууд нь усны нөөцийг хамгаалах, усны зохистой хэрэглээг хангах, амьдрах орчныг хамгаалах зэрэг үүрэг хариуцлага хүлээнэ. СГЗ-ууд нь тухайн сав газрынхаа улсын хэмжээнд болон бүс нутаг, салбар дундын устай холбоотой үйл ажиллагааны зохицуулалтыг хийдэг бол СГЗө-үүд нь орон нутгийн усны засаглалыг ил тод, оролцоог хангах зарчмаар дэмжиж ажилладаг.

⁴ Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. 2013 он. Усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө: Монгол Улс. Улаанбаатар хот.

Газрын зураг 1: Монгол улс дахь байгалийн усны нөөцийн систем




Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк

СГЗө нь 31–45 гишүүнээс бүрдсэн, дараах гурван салбарыг ижил тэнцүү төлөөлдөг төрийн бус байгууллага юм. Үүнд: (а) төрийн захиргаа болон иргэдийн хурал, (б) төрийн бус байгууллага, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, (в) үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын ус ашиглагчид. 2018 онд БОАЖЯ нь СГЗө-ийн удирдамжинд нэмэлт өөрчлөлт оруулан, одоо байгаа СГЗө-үүдийг сав газрын олон талт оролцогч талуудын платформ болгон өргөжүүлсэн билээ. Улсын хэмжээнд 24 сав газрын олон талт оролцогч талуудын платформ саяхан байгуулагдлаа.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Засгийн газрын хамтран хэрэгжүүлсэн Монгол улсын усны аюулгүй байдлын үнэлгээ техникийн туслалцааны төслийн хүрээнд үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй 21 СГЗ-дын гүйцэтгэлийг бенчмаркингаар үнэлсэн юм.⁵ Тухайлбал, СГЗ-дын үйл ажиллагааг 0 (хамгийн муу)-ээс 4 (хамгийн сайн) -ийн хооронд гүйцэтгэлийн үндсэн 14 үзүүлэлтээр үнэллээ. 5-р хуудасны зураг дээр СГЗ-ны үнэлгээний одоогийн оноо болон 2020 онд биелүүлэхээр тавьсан зорилтыг харуулав. Уг үнэлгээнд Азийн сав газрын байгууллагуудын сүлжээнээс боловсруулсан бенчмаркинг тогтоох арга зүйг ашигласан болно.

⁵ АХБ. 2014. Монгол Улсын усны аюулгүй байдлын үнэлгээ хийх техникийн туслалцаа. Манила (ТА 8855-МОН).

Газрын Зураг 2: Монгол улсын засаг захиргааны хил болон голын сав газрууд



Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк


Энэхүү үнэлгээнд СГЗ болон СГЗө-ийг хамруулж, тэдгээрийн чиг үүргийг бүхэлд нь үнэлэх зорилго агуулсан. Бенчмаркинг үнэлгээ нь СГЗ-ны албан хаагчид, СГЗө-ийн төлөөлөлтэй нягт хамтран ажиллаж, өөрсдийгөө үнэлэх явц юм. Эдгээр мэргэжилтнүүд болон төлөөллүүд нь тухайн байгууллагынхаа нөөц чадавх болон нийцтэй байдал зэргийг үнэлэх чадвартай хүмүүс байна.⁶ Үнэлгээний загвар нь үнэлгээ хийгчдэд тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлж, дараагийн бенчмаркинг тогтоохоос өмнө (2020 оны 12-р сард санал болгосон) авч хэрэгжүүлэх зөвлөмжийг нэгтгэн дүгнэх боломж олгодог.

Үнэлгээнээс гарсан чухал дүгнэлт бол СГБ-ууд, чиглэлийн яамдууд, орон нутгийн засаг захиргаа (аймаг, сум) хоорондын харилцан уялдаа холбоо хангалтгүй байгааг тодорхойлсон явдал байв. Үүнээс гадна СГЗө-г байгуулж үйл ажиллагаа явуулах асуудал СГЗ-даас ихээхэн хоцрогдолтой байгааг тодорхойлсон юм. СГЗ-ууд нь цомхон (10 хүрэхгүй ажилтантай) бөгөөд мэргэжлийн зөвлөгөө өгөхөд аймаг, сумдаа үнэлэгдэхгүй байх магадлалтай. Энэ нь СГБ-уудад хуваарилсан төсөв хангалтгүй байгаатай холбоотой юм. Эцэст нь хэлэхэд, хөрөнгө оруулалтын болон бодлогын шийдвэр гаргахад олон агентлагууд оролцдог хэдий ч СГБ-ууд нь эдгээр шийдвэр гаргах үйл явцын гадна үлддэг байна.

⁶ Жишиг тогтоох үнэлгээний үйл явцад СГЗ тус бүрээс 4–6 төлөөлөл оролцсон боловч СГЗө-өөс төлөөлөл оролцоогүй.

Бенчмаркинг үнэлгээний дундаж оноо 1.8 (4.0-өөс) гарсан байна. Энэ нь 21 СГБ-ууд нь усны нөөцийн менежментийн суурь чадавхитай болсныг харуулж байгаа юм. Дараагийн алхам бол СГБ-уудыг усны нөөцийн тогтвортой менежментийн хөдөлгөгч хүч болгоход түлхэц өгөх (өөрөөр хэлбэл одоогийн хяналт мониторинг хийх болон дэмжлэг үзүүлэх үүргээс илүү) мөн аймаг, сум, засгийн газарт тэдний хийж буй ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх явдал юм. Үүний тулд, санхүүжилт дутагдах, аймаг, сумдын захиргаа болон усны салбарын агентлагууд хоорондын харилцаа холбоо сул, мэргэжлийн чадавх, хүний нөөц дутагдалтай, мөн СГЗө-ийг байгуулах үйл явц удаашралтай зэрэг үндсэн сул талуудыг арилгах хэрэгтэй.

Оролцогч Сав газрын захиргааны Бенчмаркинг үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлтээр



СГБ= Сав газрын байгууллага.

Тэмдэглэл: Оноо нь 0 хамгийн муу, 4 нь хамгийн сайн болохыг харуулж байна.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк. 2017. Монгол Улсын усны аюулгүй байдлын үнэлгээ. Зөвлөхийн тайлан. Манила (ТА 8855-МОН).

БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

СГБ-ууд нь Монгол улсад УННМ-ийг хэрэгжүүлэх гол институци юм. Усны менежментийн чиглэлээр тодорхой шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг тул СГЗ-ууд нь аймаг, сумтай нягт уялдаатай ажиллах ёстой. Одоогийн байгаа түвшинд, (БОАЖЯ-ны бүтцэд 4-т дурдсан) ихэнх шийдвэрүүд нь БОАЖЯ-аар дамждаг тул СГЗ-ны бие даасан байдал хязгаарлагдмал юм. Түүнээс гадна, салбар дундын шийдвэртэй холбоотой асуудлыг Усны үндэсний зөвлөл удирдаж, шийдвэрлэдэг. Төвлөлийг сааруулсан орон нутгийн тогтолцоо болон СГБ-уудын төвлөрсөн тогтолцоо нь шийдвэр гаргах явцыг төвөгтэй, үр ашиггүй болгож улмаар үр нөлөөг нь бууруулдаг. СГБ болон аймаг, сумдын засаг захиргаанд хүлээлгэх хариуцлагын түвшинг нарийвчлан тодорхойлох замаар төв болон орон нутгийн хяналтыг тэнцвэртэй байдалд хүргэх шаардлагатай.

СГБ-уудын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа хоёр дахь шалтаан бол үйл ажиллагаа явуулахад шаардагдах

хөрөнгө санхүүгийн дутмаг байдал юм. СГБ-ууд нь хэрэглэгчдийн усан хангамжийн болон ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрөөс санхүүждэг. СГБ-уудын одоогийн төсөв нь ус ашиглалтын төлбөрийн дөнгөж 35%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний дийлэнх (80%) нь СГЗ-ны ажилчдын цалин хөлсөнд зарцуулагддаг. СГЗө-үүдэд төсөв хуваарилагддаггүй тул үйл ажиллагаа явуулахад маш хүндрэлтэй. Энэ шалтгааны улмаас ихэнх СГБ-ууд СГЗө байгуулж чадахгүй байна. СГБ-уудыг идэвхжүүлэхийн тулд (жишээлбэл, нэмэлт хяналт мониторинг, судалгаа хийх замаар) мөн СГЗө-үүдийн үйл ажиллагааг жигдрүүлэхийн тулд төсвийг нь нэмэх хэрэгтэй.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

Монгол Улсад УННМ -ийн тухай ойлголт харьцангуй шинэ бөгөөд СГБ-д түшиглэсэн сав газрын төлөвлөлт, менежмент зэрэг хандлагууд ч мөн саяхан үүссэн. СГЗ болон аймаг, сум, оролцогч талуудын (СГЗө) төлөөллийн УННМ-ийг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх нэн шаардлагатай байна. Сургалтын хөтөлбөрт гол зорилтууд, сургалтын төрлүүд,

мониторинг хийх журмыг нарийвчлан тусгасан жил бүрийн сургалтын төлөвлөгөө, мөн 5 жилийн төлөвлөгөөг багтаасан байх хэрэгтэй. Ажлын байран дээрх дадлагажих сургалтаас гадна танхимын сургалттай хослуулах шаардлагатай. Сургалтын хөтөлбөрт дараах үндсэн сэдвүүдийг оруулсан байх ёстой. Үүнд:

- Усны нөөцийн системийн талаарх ойлголт (аймаг, сум, СГЗ-ийн техникийн бус ажилтнуудад зориулсан);
- УННМ-ийн засаглал (оролцогч талуудын оролцоо, шийдвэр гаргах үйл явц); мөн
- Тухайн сав газрын онцлогийг багтаасан нарийвчилсан мэдээлэл (газрын доорх ус, усны чанар гэх мэт).

ТЕХНОЛОГИЙН БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ДЭМЖЛЭГ

СГЗ-дын шаардлагатай бүх чиглэлийн нарийн мэргэжилтний орон тоог бий болгох нь төвлөрсөн бус удирдлагатай СГБ-д үр ашиггүй байдаг. Тиймээс, СГБ-ууд нь хэрэгцээ шаардлага гарсан үедээ нарийн мэргэжлийн мэргэжилтэн авч ажиллуулах бололцоотой байх хэрэгтэй. Энэ нь бенчмаркинг үнэлгээний үеэр маш чухал асуудлын нэг болж хэлэлцүүлэгдсэн. Богино хугацааны тусгай сургалтууд нь мэдлэг, чадавхийг дээшлүүлэх зарим нэг шаардлагыг хангах боломжтой ч нарийн мэргэшсэн мэргэжилтэн орлож чадахгүй юм. Мэргэжлийн өндөр түвшний ур чадварын жишээ бол нөхөн сэргээгдэх газрын доорх ус болон байгалийн урсацын хэрэгцээг тодорхойлох, хил дамнасан усны менежмент, уур амьсгалын өөрчлөлт, мэдээллийн сан бүрдүүлэх, компьютерийн загварчлал зэрэг юм.

Усны нөөцийн менежментийн мэргэжилтнүүдийн нэгдсэн төв байгуулах, академи болон хувийн хэвшлээс мэргэжилтэн авч ажиллуулах боломжийг хангах зэргээр мэргэжлийн дэмжлэг үзүүлэх хувилбар байж болох юм. Энэхүү экспертүүдийг СГБ-ууд авч ажиллуулах боломжтой болох бөгөөд Усны үндэсний зөвлөл, салбарын агентлагууд, БОАЖЯ-ны ажилтнуудад дэмжлэг үзүүлэх болно. Мэргэжлийн байгууллагаар дамжуулан (жишээ нь, их сургуулиас) байнгын гэрээ хийж шаардлагатай мэргэжилтнүүдийг ажиллуулж болох юм.

Үйлчилгээний нөхцөл, ажлын удирдамж нь үйлчлүүлэгчдийн онцлог хэрэгцээнд нийцсэн уян хатан байх ёстой бөгөөд үнэ хөлсийг урьдчилан тохиролцсон байна.

АХБ-НЫ ОРОЛЦОО

АХБ нь усны менежментийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай техникийн туслалцаа, буцалтгүй тусламж,

зээлийн төслүүд хэрэгжүүлэх замаар хамтран ажиллаж байна. 2017 онд Монгол Улсын усны аюулгүй байдлын үнэлгээ техникийн туслалцааны төсөл хэрэгжиж дуусан бөгөөд энэ төслийн хүрээнд усны аюулгүй байдлыг



Чадавх бэхжүүлэх сургалт. Сав газрын олон талт платформ байгуулах сургалтыг 2018 онд зохион байгуулсан (фото зургийг АХБ-ны ТА8855-МОН төслийн багийнхан авав).

таван гол хэмжүүр (хөдөөгийн өрх, эдийн засаг, хот суурин газар, байгаль орчин, устай холбоотой гамшигт тэсвэртэй байдал)-ээр өнөөгийн усны нөхцөл байдлыг үнэлж, тогтолцооны дүн шинжилгээ хийж, мөн усны салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санал болгосон (тайлбар 5). Монгол улсын усны засаглалыг бэхжүүлж, энэхүү бодлогын тоймд дурдсан институцийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Усны засаглалыг сайжруулахад шинэ арга барил нэвтрүүлэх нь” техникийн туслалцааны төсөл шинээр хэрэгжүүлж байна.⁷

ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

Монгол улс 29 усны сав газартаа СГБ байгуулах замаар УННМ-ийг хэрэгжүүлэх ажлаа амжилттай эхлүүлэв. Сайн эхлэл тавигдсан боловч СГБ-г усны тогтвортой менежментийн хөдөлгөгч хүч, илүү нэр хүндтэй институт болгон бусад төрийн байгууллагууд болон олон нийтэд хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дараах алхмуудыг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Усны нөөцийн менежментэд оролцож буй байгууллагуудын үүрэг, ялангуяа СГБ-уудын үүрэг оролцоог тодорхой болгох журам болон бодлогын зохицуулалтуудыг уялдуулах;
- Хүний нөөц, санхүү төсөв, нарийн мэргэжлийн хувьд СГЗ-дыг бэхжүүлэх; мөн
- СГЗ, чиглэлийн яамд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон орон нутгийн иргэд хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах.

⁷ АХБ. 2017. Монгол Улсын усны засаглалыг сайжруулахад шинэ арга барил нэвтрүүлэх нь техникийн туслалцааны төсөл. Манила (ТА 9440-МОН).

Азийн Хөгжлийн Банкны тухай

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ хүртээмжтэй, тогтвортой, эрсдлийг даван туулах чадвартай хөгжлийг бүс нутагт цогцлоохын төлөө тууштай ажиллаж байна. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, хувьцааны хөрөнгө оруулалт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.

Азийн Хөгжлийн Банкны Тойм нь АХБ-ны ажилчид, мэргэжилтнүүдийн бэлтгэсэн баримт бичиг, тэмдэглэлд үндэслэдэг. Уг цуврал нь мэдээлэлд үндэслэсэн хэлэлцүүлгийг дэмжих үүднээс цаг үеийн тулгамдсан бодлогын асуудлын талаар хураангуй, техникийн бус мэдээллээр олон нийтийг хангахад зориулагдсан болно. Харилцаа холбооны газар уг цувралыг эрхлэн гаргадаг.

Энэхүү хэвлэлд илэрхийлэгдсэн үзэл санаа нь зохиогчдынх бөгөөд түүнд АХБ, Захирлуудын зөвлөл эсвэл тэдгээрийг төлөөлж буй засгийн газруудын үзэл баримтлал, бодлогыг тусгаагүй болно. АХБ нь мэдээллийг хувийн болон арилжааны бус зорилгоор АХБ-ны нэрийг дурдсаны үндсэн дээр хэвлэх, хуулбарлахыг зөвшөөрнө. Хэрэглэгчид АХБ-ны бичгээр үйлдсэн албан зөвшөөрөлгүйгээр нийтлэлийг дамжуулан худалдах, дахин түгээх эсвэл арилжааны зорилгоор хувирган ашиглахыг хориглоно.

Азийн Хөгжлийн Банк
6 АХБ Өргөн чөлөө, Мандалуёнг хот
1550 Метро Манила, Филиппин
Утас +63 2 8632 4444
Факс +63 2 8636 2444

www.adb.org/publications/series/adb-briefs



Криетив коммон атрибюшн 3.0 IGO лиценз (CC BY 3.0 IGO)

© 2020 АХБ. Уг CC лиценз нь тус хэвлэлд дурдагдсан АХБ-ны бус зохиогчийн эрхтэй материалд үл хамаарна.

<https://www.adb.org/terms-use#openaccess>

<http://www.adb.org/publications/corrigenda>

pubsmarketing@adb.org